

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ  
БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 05 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Б.Чойжилсүрэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 05, 19-ний өдрүүдийн хуралдаанаараа тус тус хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төслийг иргэд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний халдашгүй байх эрхийг хангах, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зэрэг зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэх үндэслэл, нөхцөл, журмыг тогтоож боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү хүний эрхийг дээдэлж байгаа бол өмгөөлөгчийн эрхийг хуулийн төсөлд тодорхой тусгах, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хуульчдын болон мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нарын хийдэг ажлыг салгаж зааглах, үүний тулд хууль сахиулагчийн ажлыг журамласан хууль сахиулагчийн үйл ажиллагааны хууль, өмгөөллийн, яллах, шүүн таслах үйл ажиллагааг тусад нь зохицуулсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн яаж хэрэгжүүлэхтэй холбоотой процессын хууль гаргах хэрэгтэй, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр хүний эрхийн баталгаа хэрхэн хангагдсан, хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ажлын шаардлага гэсэн хоёр талыг хамтад нь авч үзэх, Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, санал авах, нэр томъёоны ойлголт нь ойлгомжгүй байгаа талаар, шүүх хуулийн байгууллагуудын албан тушаалтны хариуцлагын асуудлыг тусгах, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудыг бүхлээр нь өөрчлөх бус нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шинэчилж байх, уг хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж нэгдсэн ойлголттой болсны дараа хуулийн төслийг хэлэлцэх зэрэг саналуудыг гаргасан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар олон үйлдэлтэй гэмт хэргийн тодорхой үйлдэл дээр нь ялын асуудлыг шүүхээр шийдвэрлүүлээд энэ хугацаанд бусад гэмт хэргийг шалгах талаар хуулийн төсөлд тусгах, прокурор, шүүхийн хяналтанд ноцтой хэргүүдийг шалгаж эхлэх үйл ажиллагаа, яллагчаар тогтоох үйл ажиллагаа хоёрыг хэрхэн уялдуулж байгаа талаар, шүүгч, прокурор, өмгөөлөгч нар гүйцэтгэх ажлын шугамаар бүрдүүлсэн нотлох баримтыг үнэлэх, мэтгэлцэх зарчим туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Болд хүний эрхийг хязгаарладаг хуулийн байгууллагын албан хаагчдын улс төр, нийгэм, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх, гадаадад байгаа хүмүүсийг гэрчээр дуудаж ирүүлсэн зардлыг хэрхэн

гаргах талаар заалт нэмэх, шинжээчийг дарамталж нэг талыг барьсан дүгнэлт гаргахгүй байх, иргэн өөрөө өөрийгөө хамгаалах зохицуулалт оруулах, хүнийг хилсээр мөрдөж хэлмэгдүүлэхгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин хүнийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр, захиалгаар гэмт хэрэгтэн мэтээр мэдээлээд нотолж чадахгүй болохоор тэр гэмт хэргээр бус өөр гэмт хэрэгт ялладаг байдал хуулийн төслөөр арилсан эсэх, хөнгөн гэмт хэрэг, хүнд гэмт хэргийн процессын ажиллагааг тусад нь зохицуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан одоо хэрэгжиж байгаа хэргийн харьяаллыг эргэж харах, зорчих эрхийг нь хязгаарлана гэдэг нь хүний эрхийг зөрчиж байгаа хэлбэр, хөрөнгө оруулалт, бизнестэй холбоотой маргааныг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан хэрэг бүртгэгч эрх бүхий албан тушаалтан нарыг өргөжүүлсэн талаар, ял завших асуудал, өсвөр нас, насанд хүрээгүй хүүхдийн ялгаа, давхар харьяалал, нэр томъёог жигдлэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж эрүүгийн процессын хуулийн чиглэлээр мэргэшсэн гадаад улсуудын мэргэжилтнүүдийн саналыг авах, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ энэ хууль нь хүний эрхийг хангахад чиглэсэн хуулийн байгууллагын ажилтнуудын гарын авлага болох ёстой, хүний эрхийг хангаж чадах эсэх асуудалд анхаарал хандуулах гэсэн саналуудыг тус тус гаргаж байсан болно.

Түүнчлэн гишүүдээс гарсан саналын дагуу Хууль зүйн байнгын хороо 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдөр шүүх, прокурор, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагуудын төлөөлөл, эрдэмтэн судлаачдыг оролцуулан Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэн өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ГАНБАТ

